



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 08 өдөр

Дугаар А/78

Номгон

Нөөцийн өвс, тэжээл нийлүүлэх аж ахуй
нэгжтэй гэрээ байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2, 35.11, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.5, 21 дүгээр зүйлийн 21.2, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 17/57 дугаар тогтоол, аймгийн Онцгой комиссын 2023 оны Х хуралдааны тэмдэглэлийн 1.1, 3.2, 2024 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 01 дүгээр хуралдааны тэмдэглэлийн 1.1, 3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Аймгийн хэмжээнд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан хөдөө аж ахуйн салбарын 2023-2024 оны өвөл, хаврын улирлын аюулгүйн нөөцийн өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэх ажлыг түргэн шуурхай зохион байгуулсугай.

2. Нэг боодол ногоон өвсийг 22,000 (хорин хоёр мянга) төгрөгөөр нийт 10,000 боодол өвс худалдан авах гэрээг “Түйн голын төгөл” ХХК-тай байгуулан ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Т.Хишигбаатар), Хүнс, хөдөө аж ахуйн газар (У.Балжинням)-т тус тус үүрэг болгосугай.

3. Нийт худалдан авсан 10,000 (арван мянган) боодол өвсний нэг боодол тус бүрд 4,000 (дөрвөн мянга) төгрөг, нийт 40,000,000 (дөчин сая) төгрөгийн үнийн хөнгөлөлт үзүүлж 2024 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс зарцуулахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т зөвшөөрсүгэй.

4. Нөөцийн өвс, тэжээлийн худалдаанд байнгын хяналт тавьж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар (У.Балжинням), Сум дундын ойн анги (Б.Дэлгэрдалай) нарт, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага арга зүйгээр хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Батсуурь)-д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

624010287